



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/179

Улаанбаатар хот

“Төгсөгчдийн төгөл” байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлж буй “Байгалиа бүтээе” аянд ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн болон дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагч, оюутан нарыг оролцуулан “Төгсөгчдийн төгөл” байгуулах арга хэмжээг зохион байгуулахыг захирал нарт даалгасугай.

2. “Төгсөгчдийн төгөл” байгуулах арга хэмжээг зохион байгуулсан ажлын үр дүнгийн тайланг жил бүрийн 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор Боловсролын ерөнхий газарт ирүүлэхийг захирлуудад, нэгдсэн тайланг жил бүрийн 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн захиргааны удирдлагын газарт ирүүлэхийг Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нарт тус тус үүрэг болгосугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142210704